



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@sqa.gov.mn
Цахим хуудас: www.sqa.gov.mn

2024.02.22 № А-1/1021
танай _____-ны № _____-Т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан БХБЯ/20240101012/01/01 урилгын дугаартай XII.1.80 “Гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ / Төв, Зуунмод сум, 6 дугаар баг/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журамд”-д Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу олгодог БА-3.5 /Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт/ тусгай зөвшөөрлөөр дунд төвөгшилтэй барилга байгууламж, цахилгааны шугам сүлжээ болох “10 кВ болон түүнээс дээш 35 кВ хүртэл хүчдэлтэй цахилгаан цахилгаан шугам сүлжээ”-ний ажлыг гүйцэтгэхээр заасан тул Эрчим хүчний яамнаас олгодог ТЗ-2.3 “0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ” тусгай зөвшөөрлийн заалтаар дүйцүүлэн тооцож, ажил гүйцэтгүүлэх боломжтой.

Тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулгатай холбогдуулан тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

- ТШЗ 26.1. “Огноо: 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр. Цаг: 12 цаг 00 минут” гэснийг “Огноо: 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр. Цаг: 10 цаг 00 минут” гэж;
- ТШЗ 26.2. “2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр. Цаг: 12 цаг 10 минут” гэснийг “Огноо: 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр. Цаг: 10 цаг 20 минут” гэж тус тус өөрчлөв.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан болно.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324022717